



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ

АСУУЛГ

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,
Сүхбаатарын талбай 6, Утас: 26-70-16, Факс: 32-70-16,
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2020. 08. 10 № 04

Г Асуулт тавих тухай Г

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.2-т заасныг тус тус үндэслэн дараах асуултыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Танд хандан тавьж байна.

Төрийн болон орон нутгийн өмчит, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж (компани, улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар)-тэй хамаарах дараах төслийн мэдээллийг 2019, 2020 оны байдлаар гарган ирүүлэхийг хүсье. Үүнд:

1. Нийт компани, улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын тоо, тэдгээрийн байгуулагдан үйл ажиллагаагаа явуулахад үндэслэж буй эрх зүйн акт, тухайн асуудлыг эрхлэх сайд, байгууллагын харьяалал;
2. Тухайн компани, улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газарт ажиллагсадын тоо, тэдгээрийг удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалтан тус бүрээр, байгууллагын ерөнхий бүтэц, зохион байгуулалт, гэрээт албан хаагчдийн тоо, цалин, урамшууллын сан болон удирдлагын цалин, урамшууллыг байгууллага тус бүрээр;
3. Тухайн компани, улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эзэмшиж буй газар эзэмшлийн эрх улсын бүртгэлд бүртгэгдэн баталгаажсан эсэх, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийн дүн, эзэмшилд бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн (үйлдвэрлэлийн зориулалттай ачаа тээвэр, хүнд даацын машин механизмаас бусад) дэлгэрэнгүй судалгаа, тэдгээрийг ашиглаж буй албан тушаалтан бүрийн мэдээллэл;
4. Тухайн компани, улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газарт хийгдсэн аудитын болон бусад эрх бүхий хяналт шалгалтын байгууллагаас хийгдсэн хяналт шалгалтын дүнгээр илэрсэн нийтлэг зөрчил дутагдал, тэдгээрийг цаашид гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэх шаардлагатай бодлогын арга хэмжээний талаар;


5. Төрийн өмчтөг компанийн хувьцааны удирдлагыг (хувьцааны ногдол ашгийг захиран зарцуулах) Монгол Улсын Засгийн газраас ямар байгууллага, албан тушаалтнууд, ямар эрх зүйн актыг үндэслэн хэрэгжүүлж, холбогдох шийдвэрийг гаргаж буй талаарх мэдээллийг байгууллага тус бүрээр;

6. Тухайн компани, улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл зэрэг болно.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8-д заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б.ЭНХБАЯР

0000000034